



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 1113

Шивээговь сум

Шүдний кабинет хүлээн авах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 255 дугаар “Үндэсний хөтөлбөр батлах тухай” тогтоол, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Эрүүл шүд - Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөр, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн яамтай хамтран сумын Эрүүл мэндийн төвд шүдний кабинет шинээр байгуулах болсонтой холбогдуулан өрөөний тохижилт засварын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

Х.Сувданцэцэг

(Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Н.Энхтайван

(Шивээ-Овоо хувьцаат компанийн Аж ахуйн үйлчилгээний хэсгийн дарга)

Ц.Адъяа

(Сумын 1-р багийн иргэн)

Д.Сувд-Эрдэнэ

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Г.Бум-Аюуш

(Эрүүл мэндийн төвийн Нягтлан
бодогч)

Д.Ууганбат

(Эрүүл мэндийн төвийн Нийгмийн
эрүүл мэндийн ажилтан)

Б.Энхцэцэг

(Эрүүл мэндийн төвийн нярав)

2. Өрөөний тохижилт, засвар үйлчилгээний ажлыг хүлээн авах үйл
ажиллагааг чанартай гүйцэтгэхийг /Ажлын хэсэг/-т үүрэг болгосугай.

3. Шүдний кабинетын тохижилтын хөрөнгийг байгууллагын хөрөнгөнд
бүртгэн орлогодож авахыг Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч /Г.Бум-Аюуш/,
нярав /Б.Энхцэцэг/, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хөрөнгийн бүрэн
бүтэн байдлыг хангаж, хариуцан ажиллахыг Эрүүл мэндийн төвийн Нийгмийн
эрүүл мэндийн ажилтан /Д.Ууганбат/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ганчимэг

П.ГАНЧИМЭГ